



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 21 өдөр

Дугаар A/563

Арвайхээр

### Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт хүндрэх онцгой эрсдэл үүсч, өвлүйг хохирол багатай даван туулахад хүн малын усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Сант сумын нэгдүгээр баг Мөрөн-Улаан нурууны гашуун, дөрөвдүгээр багийн Хэрсэн хэмээх газар инженерийн хийцтэй гүн өрмийн худаг шинээр гаргахыг зөвшөөрсүгэй.

2. Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах аж ахуйн нэгжтэй хууль журмын дагуу гэрээ байгуулж, хяналт тавин ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

3. Дээрх худгийн 16,000,000 (арван зургаан сая) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийн 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011101285

D:My Doc. Zahiramj. Zasag darga